



**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/89

Улаанбаатар хот

**Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх,
дархлаажуулалтын арга хэмжээг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны А/87 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/399 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Багахангай дүүргийн нутаг дэвсгэр дэх шүлхий өвчинд мэдрэмтгий мал, амьтны вакцины дархлааны хугацаа дуусч байгаа тул ээлжит дархлаажуулалтын ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор шуурхай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг (Я.Батсүх)-т үүрэг болгосугай.

2.Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад тус дүүргийн өвчинд мэдрэмтгий нийт 2700 толгой мал, амьтныг вакцинжуулалтанд бүрэн хамруулаж ажиллахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж "ЦЭФ трейд" ХХК (А.Цэрэндагва)-д 1 дүгээр хорооны Засаг дарга (Н.Нямзав), 2 дугаар хорооны Засаг дарга (Б.Батзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардагдах зүү тариур халдвар хамгаалал, хөдөлмөр хамгаалал, шатах тослох материал, ажиллах хүн хүчний зардлыг хавсралтаар баталсугай.

4.Гоц халдварт өвчний дархлаажуулалтанд шаардагдах 2,489,500 (Хоёр сая дөрвөн зуун наян есөн мянга таван зуу) төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, заавар зөвлөмж өгч, мэргэжил арга зүйн болон нэгдсэн удирдлагаар ханган, санхүүгийн тайланг үйл ажиллагаа зохион байгуулж дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор ирүүлэхийг Мал эмнэлгийн тасаг (Я.Батсүх) -т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




А.СҮХБОЛД

АЖИЛ/2023 он ажил/захирамж

112000253

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 01 сарын 01 -ны өдрийн 1189 дугаар
захирамжийн хавсралт



**МАЛ АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН ЭРГИЙЛЭХ
ВАКЦИНЖУУЛАЛТ ХЯНАЛТЫН АЖИЛД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

1.Шатахуун, зүү тариур, халдвар хамгаалал, холбоо, зарлан мэдээллийн зардал

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Шатахуун А-92	л	200	2390	478,000.00
2	Тариур	ш	500	400	200,000.00
3	Зүү	ш	600	700	420,000.00
4	Нэг удаагийн бээлий	Хайрцаг	2	35000	70,000.00
5	Цэнхэр спирт	л	2	6000	12,000.00
6	Нэг удаагийн Малгай	ш	250	200	50,000.00
7	Нэг удаагийн Маск	ш	200	200	40,000.00
8	Шатахуун А-92 /вакцины татан авалт болон вакцинжуулалтын ажлын гүйцэтгэлийн үеийн хяналт шалгалтад/	л	50	2390	119,500.00
9	Хороодын албан хаагчдын утасны нэгж	нэгж	10	10000	100,000.00
Дүн					1,489,500.00

2.Ажиллах хүчний зардал

№	Ажиллах хүч	Тоо	Нэг өдрийн цалин	Нэг өдрийн нийт цалин	Ажиллах хоног	Нийт ажлын хөлс
1	Туслах ажилтан	2	50000	100000	10	1,000,000.00
ДҮН						1,000,000.00
Нийт дүн						2,489,500.00